МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.08 № 1/83

танай ______ -ны № ______ -т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА

"Жагсаалт шинэчлэн батлах тухай" Гадаадын иргэн харьяатын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/476 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6536 дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

15160573З

Doc.yam a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 01 сарын 08-ны өдрийн 6536 дугаарт бүртгэв.

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 19 өдөр Дугаар А/476 Улаанбаатар хот

## Жагсаалт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харьяатын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”-ыг нэгдүгээр, “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудас”-ыг хоёрдугаар, “Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудас”-ыг гуравдугаар, “Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудас”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Жагсаалт батлах тухай” Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2014 оны А/226 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний харьяаллын газар (Г.Билэгт)-т даалгасугай.

ДАРГА Н.УУГАНБАЯР

172301813

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 12 сарын 19 өдрийн А/476
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

## Нэг. Иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичиг

1.1. Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагч дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

1.1.1 Өргөдөл (өргөдлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргах бөгөөд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох шалтгаан, аль улсад ямар хугацаагаар ажиллаж, амьдарч байсан, хэзээ, ямар хэргээр тус улсад ирсэн, эцэг, эх, эхнэр /нөхөр/, хүүхэд нь аль улсын харьяат болох, өргөдөл гаргагч одоо аль улсад аж төрж байгаа зэрэг өөрийн болон ам бүлийнхээ байдлыг тодорхой тусгана);

1.1.1.1 Хамгийн эхний мөрөнд Монгол Улсын Ерөнхийлөгч танаа /овог, нэрийг бичнэ/ дараагийн мөрөнд …… оны …… дугаар сарын……-ны өдөр /аймаг, сум, дүүрэг/-ийг бичнэ тэрний дараагийн мөрөнд өргөдлийнхөө агуулгыг бичиж хамгийн сүүлд өргөдөл гаргасан гээд овог, нэрээ бичсэнийхээ дараа өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулна;

1.1.2 Гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхрийн, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эхийн);

1.1.2.1 Гурван үеийн намтартаа он, сар, өдөр, оршин суугаа газраа тодорхой бичиж өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулсан байна;

1.1.2.2 Хамгийн эхний мөрөнд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагч овог, нэрээ бичээд миний гурван үеийн намтар гээд 1-д өвөг эцэг, эмэг эхийнхээ 2-т эцэг, эхийнхээ, 3-т өөрийнхөө эхнэр/нөхрийн намтрыг бичээд хамгийн сүүлд гурван үеийн намтраа үнэн зөв бичсэн гээд овог, нэрээ бичээд өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулсан байна.

1.1.3 Мэдүүлгийн хуудас;

1.1.4 Монгол Улсад оршин суух үнэмлэхийн хуулбар;

1.1.5 Төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт, 16 хүртэл насны хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар;

1.1.6 Гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээ, гэрлэлтээ цуцлуулсан бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны лавлагааны хуулбар;

1.1.7 Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат болохдоо 16 нас хүрээгүй хүүхдээ тус улсын харьяат болгох хүсэлтэй тохиолдолд эцэг эхийн бичгээр гаргасан үндэслэл бүхий зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.8 16-аас 18 насны хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх тохиолдолд түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.9 Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан хүсэлт гаргагчийн хувьд түүнийг харьяалах улсын эрх бүхий байгууллагын буюу тухайн улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тодорхойлолт, албан ёсны орчуулгын хамт;

1.1.10 Сэтгэц мэдрэлийн буюу халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын талаарх эрүүл мэндийн /сэтгэцийн эрүүл мэндийн болон халдварт өвчин судлалын үндэсний төв, орон нутагт эрүүл мэндийн нэгдсэн төв/ байгууллагын тодорхойлолт;

1.1.11 Хууль ёсны амьжиргааны эх үүсвэртэй болохыг нотлох зохих бичиг баримт;

1.1.11.1 Байгууллага аж ахуйн нэгжээс гаргасан цалингийн тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

1.1.11.2 Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний хуулбар;

1.1.11.3 Амьжиргааны эх үүсвэртэй болохыг нотлох бусад баримт бичиг;

1.1.12 Оршин суугаа газрын тодорхойлолт;

1.1.13 Гэрэл зураг 2 хувь;

1.1.14 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

1.2. Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагч нь дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ;

1.2.1 Өргөдөл (өргөдлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргах бөгөөд Монгол Улсын харьяатаас гарах болсон шалтгаан, харьяат болохыг хүссэн улс, харьяат болох улсдаа шилжин суурьшсан огноо, эцэг, эх, эхнэр /нөхөр/, хүүхэд нь аль улсын харьяат болох, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх эсэх талаар тусгана);

1.2.1.1 Хамгийн эхний мөрөнд Монгол Улсын Ерөнхийлөгч танаа /овог, нэрийг бичнэ/ дараагийн мөрөнд …… оны …… дугаар сарын ……-ны өдөр /оршин сууж байгаа улс, аймаг, сум, дүүрэг/-ийг бичнэ тэрний дараагийн мөрөнд өргөдлийнхөө агуулгыг бичиж хамгийн сүүлд өргөдөл гаргасан гээд овог, нэрээ бичсэнийхээ дараа өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулна;

1.2.2 Гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхрийн, эцэг, эхийн, өвөг эцэг, эмэг эхийн);

1.2.2.1 Гурван үеийн намтартаа он, сар, өдөр, оршин суугаа газраа тодорхой бичиж өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулсан байна;

1.2.2.2 Хамгийн эхний мөрөнд Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагч овог, нэрээ бичээд миний гурван үеийн намтар гээд 1-д өвөг эцэг, эмэг эхийнхээ 2-т эцэг, эхийнхээ 3-т өөрийнхөө эхнэр/нөхрийн намтрыг бичээд хамгийн сүүлд гурван үеийн намтраа үнэн зөв бичсэн гээд овог, нэрээ бичээд өөрийнхөө гарын үсгийг зурж баталгаажуулсан байна;

1.2.3 Мэдүүлгийн хуудас;

1.2.4 Төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт, 16 хүртэл насны хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар;

1.2.5 Гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, гэрлэлтээ цуцлуулсан бол энэ тухай эрх бүхий байгууллагаас гаргасан лавлагаа;

1.2.6 16 хүртэл насны хүүхдийнхээ иргэний харьяаллыг өөрчлөх бол энэ талаар эцэг эхийн харилцан бичгээр тохиролцсон зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.7 16-аас 18 насны хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх тохиолдолд түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.8 Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан тохиолдолд өөрийн харьяаллыг олгохыг зөвшөөрсөн тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагын албан ёсны зөвшөөрөл, албан ёсны орчуулгын хамт;

1.2.9 Монгол Улсад иргэний өр төлбөр, нэхэмжлэлгүй болох талаар дараах байгууллагуудаас гаргасан тодорхойлолт;

1.2.9.1 Шүүх;

1.2.9.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

1.2.9.3 Татварын байгууллага;

1.2.9.4 Сургалтын төрийн сан;

1.2.10 Гэрэл зураг 2 хувь;

1.2.11 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

1.3 Харьяатын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчаас энэ жагсаалтын 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохих бичиг баримтыг шаардана;

1.4 Иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргагч нь гэр бүлийн гишүүдийн хамт /0-16 нас/ Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, харьяатаас гарахыг хүсвэл өргөдлөө хамтран гаргаж болно.

## Хоёр. Бусад

2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргасан өргөдөл, гурван үеийн намтар, мэдүүлгийн хуудас нь хоорондоо зөрүүгүй, үнэн зөв, он дараалын дагуу тодорхой, дэлгэрэнгүй бичнэ;

2.2 Тодорхой заасан хуулбар баримт бичгүүд нь нотариатаар гэрчлэгдсэн, гадаад хэл дээрх баримт бичгүүд албан ёсоор орчуулагдсан байна.

--oOo--

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 12.. сарын 19 өдрийн A/476
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

| **МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ БОЛОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС** | Эцэг, эхийн нэр | Өөрийн нэр |
|---|---|---|
| | | |
| | Төрсөн огноо<br>Он сар өдөр | Иргэний харьяалал |
| | Яс үндэс | Хүйс<br>☐ Эрэгтэй ☐ Эмэгтэй |
| *Санамж: Тохирох газар √ тэмдэглэгээ хийнэ үү.* | Төрсөн газар<br>Улс | Хот |

Гэрлэлтийн байдал

☐ Гэрлэсэн ☐ Гэрлээгүй ☐ Бэлэвсэн

☐ Гэрлэлт цуцлуулсан ☐ Бусад

Зураг
4 см x 6 см

(сүүлийн 6 сард авхуулсан байна)

**Санамж:** *Та мэдүүлгийн хуудсыг бөглөхийн өмнө сайтар уншиж танилцан, хар энгийн бэхээр өгөгдсөн хэсгүүдэд монгол хэлээр гаргацтай үнэн зөв бөглөнө үү.*

Гэр бүлийн байдал /зөвхөн гэр бүлийн бүртгэлд байгаа хүмүүсийг бичнэ/

| Таны хэн болох | Овог, нэр | Төрсөн огноо | Иргэний харьяалал | Оршин суугаа газар, гэрийн хаяг |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Боловсролын байдал

| Сургуулийн нэр | Хэдээс хэдэн онд суралцаж төгссөн | Хаана /улс, хот | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Хөдөлмөр эрхлэлтийн байдал

| Ажлын газрын нэр | Хэдээс хэдэн онд ажилласан | Хаана /улс, хот/ |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

## Ял шийтгэл

Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

Өр төлбөртэй эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

## Бусад мэдээлэл

Монгол Улсын харьяат болох шалтгаан

Харьяатаас гарч буй улсын нэр

Өмнө нь харьяалагдаж байсан улсын харьяатаас гарах зөвшөөрөл авсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Зөвшөөрлөл авсан огноо

Хүчинтэй хугацаа

Таны төрөл садан Монгол Улсад амьдардаг эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

______________________________

Нийгмийн даатгал, татвар төлдөг эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Монгол Улсад анх ирсэн огноо

______________________________

Монгол Улсад ирсэн зорилго

______________________________

Утасны дугаар

Цахим шуудангийн хаяг

Яаралтай үед холбоо барих хүний нэр

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Таны байнга оршин суугаа хаяг

| Улс | Хот /аймаг, нийслэл/ | Байр, гудамж | Тоот |
|---|---|---|---|
| | | | |

Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяат болох эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

## Миний хамт Монгол Улсын харьяат болох 18-аас доош насны хүүхэд

| Таны хэн болох | Овог | Нэр | Төрсөн огноо | Иргэний харьяалал |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

| Гарын үсэг | Он | сар | өдөр |
|---|---|---|---|
| / _______________ / | ☐☐☐☐ | ☐☐ | ☐☐ |

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 12 сарын 19 өдрийн А/476
дугаар тушаалын 3 дугаар хавсралт

| **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛАА СЭРГЭЭН ТОГТООЛГОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС** | Эцэг, эхийн нэр | Өөрийн нэр |
|---|---|---|
| | | |
| | Төрсөн огноо<br>Он сар өдөр | Иргэний харьяалал |
| | Яс үндэс | Хүйс<br>☐ Эрэгтэй ☐ Эмэгтэй |
| *Санамж: Тохирох газар √ тэмдэглэгээ хийнэ үү.* | Төрсөн газар<br>Улс | Хот |

Гэрлэлтийн байдал

☐ Гэрлэсэн ☐ Гэрлээгүй ☐ Бэлэвсэн

☐ Гэрлэлт цуцлуулсан ☐ Бусад

Зураг
4 см x 6 см

(сүүлийн 6 сард авхуулсан байна)

**Санамж:** *Та мэдүүлгийн хуудсыг бөглөхийн өмнө сайтар уншиж танилцан, хар энгийн бэхээр өгөгдсөн хэсгүүдэд монгол хэлээр гаргацтай үнэн зөв бөглөнө үү.*

Гэр бүлийн байдал /зөвхөн гэр бүлийн бүртгэлд байгаа хүмүүсийг бичнэ/

| Таны хэн болох | Овог, нэр | Төрсөн огноо | Иргэний харьяалал | Оршин суугаа газар, гэрийн хаяг |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Боловсролын байдал

| Сургуулийн нэр | Хэдээс хэдэн онд суралцаж төгссөн | Хаана /улс, хот | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Хөдөлмөр эрхлэлтийн байдал

| Ажлын газрын нэр | Хэдээс хэдэн онд ажилласан | Хаана /улс, хот/ |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

## Ял шийтгэл

Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

Өр төлбөртэй эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

## Бусад мэдээлэл

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох шалтгаан

Харьяатаас гарч буй улсын нэр

Өмнө нь харьяалагдаж байсан улсын харьяатаас гарах зөвшөөрөл авсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Зөвшөөрөл авсан огноо

Хүчинтэй хугацаа

Таны төрөл садан Монгол Улсад амьдардаг эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

______________________

Нийгмийн даатгал, татвар төлдөг эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Өмнө нь харьяалагдаж байсан Улсад ирсэн огноо

______________________

Өмнө нь харьяалагдаж байсан улсад амьдарч байсан зорилго

______________________

Утасны дугаар

Цахим шуудангийн хаяг

Яаралтай үед холбоо барих хүний нэр

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Таны байнга оршин суугаа хаяг

| Улс | Хот /аймаг, нийслэл/ | Байр, гудамж | Тоот |
|---|---|---|---|
| | | | |

Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяат болох эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

## Миний хамт Монгол Улсын харьяат болох 18-аас доош насны хүүхэд

| Таны хэн болох | Овог | Нэр | Төрсөн огноо | Иргэний харьяалал |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

| Гарын үсэг | Он | сар | өдөр |
|---|---|---|---|
| / _______________ / | ☐☐☐☐ | ☐☐ | ☐☐ |

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2023 оны 12 сарын 19 өдрийн А/476
дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

| **МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТААС ГАРАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС** | Эцэг, эхийн нэр | Өөрийн нэр |
|---|---|---|
| | | |
| | Ургийн овог | Регистрийн дугаар |
| | Яс үндэс | Хүйс: ☐ Эрэгтэй ☐ Эмэгтэй |
| | Төрсөн газар: Улс | Он / сар / өдөр; Хот /аймаг, дүүрэг/ |
| *Санамж: Тохирох газар √ тэмдэглэгээ хийнэ үү.* | Давхар харьялалтай эсэх: ☐ Тийм ☐ Үгүй | |

Гэрлэлтийн байдал
☐ Гэрлэсэн ☐ Гэрлээгүй ☐ Бэлэвсэн
☐ Гэрлэлт цуцлуулсан ☐ Бусад

Зураг
4 см x 6 см

(сүүлийн 6 сард авхуулсан байна)

**Санамж:** *Та мэдүүлгийн хуудсыг бөглөхийн өмнө сайтар уншиж танилцан, хар өнгийн бэхээр өгөгдсөн хэсгүүдэд монгол хэлээр гаргацтай үнэн зөв бөглөнө үү.*

Гэр бүлийн байдал /зөвхөн гэр бүлийн бүртгэлд байгаа хүмүүсийг бичнэ/

| Таны хэн болох | Овог, нэр | Төрсөн огноо | Иргэний харьяалал | Оршин суугаа газар, гэрийн хаяг |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Боловсролын байдал

| Сургуулийн нэр | Хэдээс хэдэн онд суралцаж төгссөн | Хаана | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Хөдөлмөр эрхлэлтийн байдал

| Ажлын газрын нэр | Хэдээс хэдэн онд ажилласан | Хаана /улс, хот/ |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

## Ял шийтгэл

Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

Өр төлбөртэй эсэх:

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

## Бусад мэдээлэл

Монгол Улсын харьяатаас гарах шалтгаанаа бичнэ үү

Харьяат болох хүсэлтэй улсын нэр

Харьяат болох улсын урьдчилсан зөвшөөрөл авсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Зөвшөөрлөл авсан огноо

Хүчинтэй хугацаа

Таны эцэг, эх, эхнэр/нөхөр, хүүхэд хэний асрамжинд үлдэх

Таныг Монгол Улсын харьяатаас гарахыг эцэг, эх, эхнэр/нөхөр, хүүхэд зөвшөөрч байгаа эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Утасны дугаар

Цахим шуудангийн хаяг

Яаралтай үед холбоо барих хүний нэр

Таны байнга оршин суугаа хаяг

| Улс | Хот /аймаг, нийслэл/ | Байр, гудамж | Тоот |
|---|---|---|---|
| | | | |

ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН ГАЗАР

Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяатаас гарах эсэх

☐ Тийм ☐ Үгүй

Тийм бол бичнэ үү

Миний хамт Монгол Улсын харьяатаас гарах
18-аас доош насны хүүхэд

| Таны хэн болох | Овог | Нэр | Төрсөн огноо | |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

| Гарын үсэг | Он | сар | өдөр |
|---|---|---|---|
| / ________________ / | ☐☐☐☐ | ☐☐ | ☐☐ |